



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/171

Номгон

“Төрийн тахилгат Их богд хайрхны тайлга тахилгын уламжлал, байгаль газар зүйн онцлог” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17/59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 98 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Төрийн тахилгат Их богд хайрхны тайлга тахилгын уламжлал, байгаль газар зүйн онцлог” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, Байгаль орчны салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулсугай.


2.Эрдэм шинжилгээний хурал, байгаль орчны салбарын байгууллагуудын хэлэлцүүлгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 20,000,000 (Хорин сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Эрдэм шинжилгээний хурал, байгаль орчны салбарын байгууллагуудын хэлэлцүүлгийг үр дүнтэй зохион байгуулж холбогдох тайлан, баримтыг архивд хүлээлгэн өгч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа (Б.Бат-Өлзий) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

824010355

D:\2024 ON\Zakhiramj\Захирамж.docx

Аймгийн Засаг даргын ... дугаар
сарын 15-ны өдрийн ... дүгээр
захирамжийн хэвэрэвт



“ТӨРИЙН ТАХИЛГАТ ИХ БОГД ХАЙРХНЫ ТАЙЛГА ТАХИЛГЫН
УЛАМЖЛАЛ, БАЙГАЛЬ ГАЗАР ЗҮЙН ОНЦЛОГ” СЭДЭВТ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЗАРДЛЫН
ТООЦОО

№	Зардлын нэр	Нийт үнэ
1	Эрдэмтдийн урамшуулал замын зардал	5,600,000
2	Хоол, буудлын зардал	12,080,000
3	Цайны материал	1,160,000
4	Хэвлэл, бичиг хэргийн зардал	1,160,000
	Нийт	20,000,000

оОо